

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-2

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 3-11

---

**1.Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2024.09.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/** 3-11

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
12 дугаар сарын 03-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 41 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

**Томилолттой:** Б.Батбаатар, Б.Дэлгэрсайхан, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр;  
**Чөлөөтэй:** О.Амгаланбаатар, Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Ө.Шижир;  
**Эмнэлгийн чөлөөтэй:** Н.Номтойбаяр.

**Нэг.Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2024.09.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Гадаад хамтын ажиллагааны газрын ахлах шинжээч Г.Одбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, С.Эрдэнэболд, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, С.Эрдэнэболд нар үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 3  
Бүгд: 14  
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Р.Эрдэнэбүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 14 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 92.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн тухай Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 36 минут үргэлжилж, 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 17 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
13 цаг 41 минут.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Ингээд 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

**Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр ирүүлсэн.**

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцье.

Холбогдох баримт бичгийг та бүхэнд, гишүүдэд бас тараасан байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Батлан хамгаалахын сайд Бямбацогт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг, Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга Энхболд, Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын ахлах шинжээч Одбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Ингээд Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт сайд танилцуулна. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

**С.Бямбацогт:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн амрыг эрье.

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах асуудлыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулж байна.

Монгол Улс, Япон Улс хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны айлчлал, солилцоо, цэргийн сургалт бэлтгэл, хуурай замын цэрэг, агаарын цэрэг хоорондын хамтын ажиллагаа, инженерийн цэрэг болон цэргийн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалт, дадлагад оролцох зэрэг өргөн хүрээтэй хэрэгжиж ирсэн. Хоёр улсын Засгийн газар хооронд 2015 онд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр Батлан хамгаалах яамд хооронд 2012 онд батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан бөгөөд 2024 оны 2 дугаар сард Батлан хамгаалахын сайдын Япон Улсад хийсэн айлчлалын үеэр уг санамж бичгийг шинэчлэн гарын үсэг зурсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн 2022 онд Япон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан Монгол Улс, Япон Улсын энх тайван, хөгжил, цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулахад асуудал тусгагдсан. Үүнийг хэрэгжүүлэх зорилгоор 2023 оны 3 дугаар сард Гадаад харилцааны яамнаас чиглэл авч хоёр талын ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.

Хоёр талын ажлын хэсгийн бэлтгэл уулзалтыг 2023 оны 10 дугаар сард цахимаар зохион байгуулсан ба хэлэлцээр албан ёсны зөвшилцөл эхэлж, талууд 2024 оны 2, 3, 5, 6, 7 дугаар саруудад хэлэлцээрийн төслийг харилцан солилцсон хоёр талын ажлын хэсгийн уулзалт 2024 оны 7 дугаар сард дахин цахимаар зохион байгуулж, хэлэлцээрийн төслийн агуулгыг эцэслэн тохирсон.

Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах асуудлыг Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөх, мөн холбогдох Байнгын хороо дэмжсэн тохиолдолд уг хэлэлцээрт гарын үсэг зурах, эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийг ажлын шугамаар гаргахаар тогтсон.

Уг Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулсан нь хоёр улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратеги түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж, батлан хамгаалах салбарын харилцаа хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, бүс нутагт цэргийн идэвхжилийг бэхжүүлэх, цэрэг, техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэж, Япон улсаас орчин үеийн батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах, Монгол Улс дэвшигчдийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Тус хэлэлцээр олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6-д заасны дагуу заавал соёрхон батлуулах хэлэлцээрт хамаарна.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Г.Тэмүүлэн:** Бямбацогт сайдад баярлалаа. Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Кнопоо дарцгаагаарай манайхан.

Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Наранбаяр сайд асуулт асууна.

**П.Наранбаяр:** Баярлалаа, товчхон асууя. Энэ хэрвээ нууц биш бол чухам ямар технологи, техник, тоног төхөөрөмж бий вэ? Голлож энэ гамшгийн асуудлаар юм уу эд нар гэж ойлгосон зөв үү?

Хоёр дахь нь болохоороо энэ 2 дугаар зүйлийн 2.2-т заасан хамтарсан хороо хоёр улсын үндэсний ажлын хэсгээс бүрдэнэ гэххээд Япон талыг нь харахаар Батлан хамгаалах яамнаасаа гадна Гадаад харилцаа, эдийн засгийн худалдаа буюу МЕТІ гээд эдний яамны бас байдаг. Энэ гурваас орж ирсэн. Манайхаас зөвхөн Батлан хамгаалах яам гээд тэгээд Батлан хамгаалах яамнаас томилсон гээд бусад холбогдох байгууллагын төлөөлөгчид байна гээд заасан байна. Тэгэхээр энэ дээр яагаад ингэсэн юм бол? Энэ манай Гадаад харилцааны яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас бас оруулж болоогүй юм уу? Бас энэ төсөв, мөнгөтэй холбоотой асуудал бас яригдах болов уу гэж бодож байна.

Түүний зэрэгцээ энэ 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг дээр Монгол Улс энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ шилжүүлэн өгөх батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи, түүний шилжүүлэн өгөхөд оролцох этгээд шилжүүлэн өгөхтэй холбоотой нарийвчилсан зүйл, нөхцөл зэрэг тохиролцоог талуудын эрх бүхий байгууллагууд хийнэ гэххээд Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаар Батлан хамгаалахын яам гэж зөвхөн нэг яаманд заасан байгаа юм. Япон улсын Засгийн газрын хувьд бол эрх бүхий байгууллагаар Батлан хамгаалах яам, Эдийн засаг, худалдаа үйлдвэрийн яам байна гээд заасан. Манайх бас энэ дээр зөвхөн Батлан хамгаалахыг яагаад оруулсан бэ?

Дээр нь нэмээд энэ 4 дүгээр зүйл дээр нууц мэдээллийг хамгаалах арга хэмжээг зөвхөн Батлан хамгаалах яам гэсэн байгаа юм. Энэ манайхаас нэмэгдэх ёстой юу, үгүй юү? Энэ зүйлүүдийг тодруулж асуух гэсэн юм. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Бямбацогт сайд асуултад хариулъя. Бямбацогт сайд асуултад хариулъя.

**С.Бямбацогт:** Тийм. Уг хэлэлцээрийг байгуулснаараа бид нар хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл гээд үйл ажиллагааны хөтөлбөр баталсан байгаа. Энэ хөтөлбөрийн хэрэгжилт хангагдах ийм бас бололцоотой болно. Энэ хүрээнд орж ирэх тоног төхөөрөмж, техникийн туслалцаа бол үндсэндээ Монгол Улсын батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлэх, гэхдээ үйл ажиллагааных нь зорилго нь бол үндсэндээ НҮБ-ын холбогдох дүрмийн хүрээнд явагдах үйл ажиллагаа гэж хэлэлцээрт тодорхой туссан байгаа.

Өөрөөр хэлэх юм бол оруулж ирж байгаа тоног төхөөрөмж, техник технологийг бид нар яг ийм зориулалтаар ашиглана гэдгээ энэ хэлэлцээр дотроо маш тодорхой тусгасан гол бас агуулга нь үндсэндээ энхийг сахиулах болон энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх түншлэлийн гэрээнд заагдсан энэ үйл ажиллагаанд зориулагдана гэж бас ойлгож болно.

Хоёр дахь асуултын талаар тэр яагаад зөвхөн Батлан хамгаалах яамнаас зураад байгаа юм, Гадаад харилцааны яагаад зурахгүй байгаа юм манайхан хариулчих уу.

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулъя 4 номер Ганхуяг дарга.

**Д.Ганхуяг:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Эрхэм гишүүний асуултад хариулъя.

Ер нь өнгөрсөн онд манайх хамгийн сүүлд Арабын Нэгдсэн Эмират Улстай цэргийн хамтын ажиллагаа тогтоогоод ингээд нийт 39 оронтой цэрэг, хамтын ажиллагааг явуулж байгаа. Энэ дотроо Япон улс маань бас орчихсон байгаа. Яагаад өнөөдөр ингээд явж байна гэхээр өшөө Засгийн газрын энэ түвшинд батлан хамгаалах салбар дээрээ сууриалаад цэрэг, техникийн тусламж, сургалт, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр явна. Цаашдаа бусад төлөөлөл гэдэг утга бол ахиад цаашдаа эдийн засгийн хүрээнд бусад яамдын чиглэлээр явбал энэ ингээд дэлгэрэнгүй болоод явах юм. Эхний ээлжид батлан хамгаалах салбар дээрээ сууриалаад ингээд эхний ажлын хэсгийн ажил ингэж эхлэх юм.

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулах уу? Хангалттай юу Наранбаяр сайд? Нэмж тодруулъя Наранбаяр гишүүн. Наранбаяр гишүүн.

**П.Наранбаяр:** Яах вэ, энэ ойлголоо ойлголоо. Би энэ хэлэлцээрийг дэмжиж байгаа шүү дээ. Зүгээр яг хэлэлцээрийг хийж байгаа талууд хоорондоо бас ижил түвшний байх шаардлага байдаг. Тэр утгаараа цаад талд нь Гадаад харилцааны яам МЕТІ буюу тэр Эдийн засаг, худалдааны яам нь орж ирээд Батлан хамгаалах яам гэсэн үг гурван юм ажлын хэсгийн хороон дээрээ орж ирчхээд, манайх ганцхан Батлан хамгаалах яам, тэгээд өөрийнх нь томилох, холбогдох байгууллага гээд ингээд яаж байгаа тэрийг л тодруулж асууж байгаа юм. Зүгээр манай Гадаад харилцааны яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ хамтын энэ хамтарсан хороонд чинь ажлын хэсэгт чинь байж болоогүй юм уу? Дээр нь нэмээд тэр 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн асуулт, 4 дүгээр зүйлийн тэр асуулт гээд иймэрхүү асуулттай шулуухан шулуухан шууд хариулчих л даа. Тэнэг хүн өмнөө суулгаж байгаа юм шиг ингээд байх юм.

**Г.Тэмүүлэн:** 3 номер, 3 номер.

**Г.Энхболд:** Эрхэм гишүүний хариултад хариулъя. Хуулийн хэлтсийн дарга Энхболд.

Тэгэхээр энэ хоорондын хэлэлцээр батлагдсанаараа үндсэндээ Монгол Улс хүлээн авагч байгууллага гэдэг утгаараа Японы тал бол манайд тодорхой батлан хамгаалах чиглэлээр техник, тоног төхөөрөмж өгнө гэдэг утгаараа энэ бусад яамдууд нь хамаардаг юм байна лээ. Заавал тэд нар нь оролцчихсон оролцоотой байдаг.

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэболд:** Гурван асуулт байна. Нэгдүгээрт нь болохлоороо энэ батлан хамгаалах техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай

хоёр улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр гэж байгаа. Энэ Японтой холбоотой хэлэлцээр яригдаж байна. Өмнө нь хэчнээн улстай ийм төрлийн хэлэлцээр манайх хийгдсэн юм, тийм туршлага нь ямар байгаа юм бэ гэсэн нэгдүгээр асуулт. Цаашид ер нь Японоос гадна хэчнээн улстай ийм төрлийн хэлэлцээр хийхээр төлөвлөж байгаа юм бэ? Магадгүй нууцтай холбоотой асуулт байвал бас тодорхой хэлчхээрэй.

Хоёрдугаар асуулт нь болохлоор тэр талууд тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг анхааралдаа авч гэсэн хэллэг байна. Яг анхааралдаа авч гэдэг нь яг ямар утгатай, ямар тодорхойлолттой зүйл юм бэ? Анхааралдаа авна гэдэг чинь тийм пассив төлөвийн буюу идэвхгүй төлөвийн үг байна л даа. Тэгэхээр энэ нь яг ямар агуулгатай, хамтран тодорхойлох гэж байгаа тэр хамтран тодорхойлох гэдэг нь бас ямар агуулгатай юм бэ? Тэр дипломат шугамаар баталгаажуулна гэдгийг нь. Энэ 3 агуулга ямар утгатай юм бэ гэдэг.

Гуравдугаарт, тэр гэрээн дээр бас 5.1 дээр нь тэр төсвийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлнэ гэхчхэн байгаа. Ер нь энэ асуудал яригдахаар бид нар ямар хэмжээний төсвийн тухай яригдах юм бэ? Энэ нэг удаагийнх юм уу? Эс үгүй бол тогтмол удаа, байнгынх юм уу гэсэн энэ дээр нь төсөвтэй холбогдуулаад бас тайлбарлаж өгөөч. Энэ гурван асуулт асууя.

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. 4 номер.

**Д.Ганхуяг:** Эрхэм гишүүний асуултад хариулъя.

Ер нь нөгөө Эдийн засгийн яам, Гадаад яамаа заавал зайлшгүй оруулж байж бусад улсад тусламжаар, хандивын шугамаар ингэж техник, тоног төхөөрөмж, боловсон хүчин бэлтгэхэд нь шийдвэрээ гаргадаг. Ингэж шийдвэрлэсний дараа аюулгүй байдлаа заавал төрийн бус байгууллагаар хэрэгжүүлдэг юм байна лээ Японы тал. Тэрийг тэр аюулгүй хэрэгжүүлэх төрийн бус байгууллага нь тухайн улсаасаа аюулгүй байдлын гэрчилгээгээ авсны үндсэн дээр Монгол Улстай харьцаад тусламж, дэмжлэг үзүүлэх чиглэлээрээ хоёр тал гарын үсэг зурж энэ арга хэмжээ хэрэгждэг. Төсөвтэй холбоотой зардал бол зөвхөн манайх зарим тохиолдолд тээврийн зардлаар төлнө. Бусад тохиолдолд өөр зардал гарахгүй. Ихэнх зардал, ихэнх тохиолдолд үнэгүй хандивын шугамаар ингэж орж ирнэ.

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

**С.Эрдэнэболд:** Тодорхой асуултад хариулмаар байна. Эхлээд асуусан шүү дээ. Хэчнээн улстай ийм төрлийн хэлэлцээр байгаа юм бэ? Хэчнээн улстай хэлэлцээр байгуулах юм бэ гээд. Энэ асуултад хариулсангүй.

Хоёрдугаарт нь тэр танаас аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг анхааралдаа авч гэдгийг нь яг юу гэж хэлээд байгаа юм бэ гэдгийг та тодорхой яг хэлмээр байх юм. Япон улс төрийн бус байгууллагаар хэрэгжүүлдэг гээд байна. Яг энэ яг ямар агуулгатай юм? Хамтран тодорхойлох гэдэг нь юу гэж байгаа юм? Тэр 3 дахь асуултад хариулсан гэж тооцлоо. Эхний 1, 2 дугаар асуултад тодорхой хариулж өгөөч.

**Г.Тэмүүлэн:** 4 номер

**Д.Ганхуяг:** Ер нь батлан хамгаалах салбар нийт 39 улстай ийм байдлаар харьцаж байгаа. Энэ дотроо бол Япон Улс орчихсон байгаа. Аюулгүй байдлаар бол цэрэг, хамтын ажиллагааны чиглэлээр энэ нууцалсан гэрээний зарчмаар арга хэмжээнүүд заагдсан манай Тагнуулын ерөнхий газраас бас гэрээ хийхээс өмнө шалгагдаж байгаа энэ системээр явдаг. Цаашдаа бид өшөө улс орнуудаа нэмэхийг эрмэлзэж байгаа. Яг одоо бол яг тэр улстай гээд хэлчихээр нэр нь бас болохгүй байна. Ер нь жилээс жилд ингээд өссөөр байгаад нийт 39 улс оронтой цэрэг, хамтын ажиллагаа үүсээд, харилцаа их өндөр түвшинд явж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Сая Эрдэнэболд гишүүний асуултад хариулсан уу тэр 1.2 дээр байгаа анхааралдаа авч, дипломат шугамаар баталгаажуулна гэсэн нь ямар утгатай юм бэ гэдэг асуулт асуух шиг болсон. Болно, болно, нэмж тодруулж болно шүү дээ. Тодруулах уу? Ганхуяг дарга хариулах уу эхлээд? Хариулчихъя, тэгээд дараа нь нэмээд тодруулъя.

**Д.Ганхуяг:** 1.2 дээр ер нь талууд тодорхой төсөл хэрэгжүүлэхдээ тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг анхааралдаа авч хамтран тодорхойлох бөгөөд дипломат шугамаар баталгаажуулна гэхийсэн байгаа. Энэ нь бүгд хоёр улсын Тагнуулын ерөнхий газар энэ гэрээний өмнө энэ аюулгүй байдал, мөн Батлан хамгаалах зөвлөлөөрөө орж байж дараагийн асуудлууд ингээд яригдаад явдаг журамтай.

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

**С.Эрдэнэболд:** Энэ яах вэ зүгээр бид нар нөгөө ийм эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр ч юм уу биш байхгүй юу. Энэ чинь өөрөөр хэлбэл нөгөө батлан хамгаалах салбар, аюулгүй байдалтай холбоотой асуудал. Яагаад энэ зүйлийг би тодруулж асуугаад байгаа шалтгаан нь болохлоор одоо манай бүс нутаг чинь өөрөө асуудалтай, хямралтай байна, энэ хойд хөршийн маань хувьд нөхцөл байдалд орчихсон, цагийн байдал үүсчихсэн ингээд өөрөөр хэлбэл, энэ дэлхий нийтийн олон улсад болж байгаа энэ сонгууль, сонгуулийн зэрэгцээ явж байгаа энэ цэрэг, эдийн засаг, стратегийн нөхцөл байдал маань асар хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа үед магадгүй энэ бол бас нээлттэй яригдах сэдэв биш байх.

Гэхдээ нөгөө талдаа бол Монгол Улс бас энэ хоёрдмол агуулгатай тодорхойгүй тийм мессежийг олон улсад, ялангуяа бүс нутагтаа гаргаж болохгүй ээ. Тэгэх юм бол юу гэдэг юм, энэ зэвсэглэлийн асуудал энд яригдаж болно. Батлан хамгаалахын тоног төхөөрөмж гэдэг чинь янз бүрийн олон төрлийн үйлдэл, зорилготой зүйл байгаа шүү дээ тэр. Энэ дээрээ бол мэдээж бол ойлгож байгаа. Гэтэл энэ нэг улс нөгөө улстай болж байгаа үйл явдал ч юм уу энэ.../минут дуусав./

**Г.Тэмүүлэн:** Санал гэж ойлголоо. Тийм, санал гэж ойлголоо.

Батсүмбэрэл гишүүн асуулт асууна.

**Н.Батсүмбэрэл:** Зарим асуулт давхацсан маягтай байна. Тэгэхдээ тодруулчихъя. Тэр тэгш байх зарчим зөв байх Наранбаяр гишүүний асууж байгаа. Монгол Улсын Гадаад хэргийн яам, Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам

албан ёсоор оролцохгүй гэдгээ бичгээр өгсөн юм уу? Эс үгүй бол яагаад энд оролцохгүй байгаа юм? Нэг.

Хоёр дахь нь Наранбаяр гишүүн өөрөө Засгийн газрын гишүүн, сая асуултад хариулж байгаа байдлаар Засгийн газрын хурлаар энэ орсон гээд байдаг, эс үгүй бол Засгийн газрын хурлаар орсон материал юм уу? Эс үгүй бол ороогүй сая сайд нэмж энд асууж байгаа юм уу? Энийг бүүр тодруулж хариулт авъя. Сүүлийн үед энэ цахим аюулгүй байдлын асуудал бид танай яам дээр очиход ч гэсэн бас бид нарт танилцуулж байсан шүү дээ. Цахим аюулгүй байдлын асуудал гараад байдаг. Энэ дээрээ тэр тодруулж, манайх чинь өөрөө цахим яамтай байж байна, цахим чиглэлийн Байнгын хороо байж байна. Энийг хэрхэн та нар оруулж үзэж байгаа юм бэ? Магадгүй тэр сүүлийн хэсэгт яригдаад байгаа асуудлын нэг хэсэг нь тэр цахим аюулгүй байдлын асуудал болж таарч байгаа. Тэгэхээр энэ дээр хариулт аваадахъя.

**Г.Тэмүүлэн:** Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Бямбацогт сайд.

**С.Бямбацогт:** Тэгэхээр түрүүн, сая манай Төрийн нарийн бас хариулчихсан. Ерөнхийдөө хүлээж авч байгаа бид нар. Энэ асуудлыг Засгийн газрын хоорондын хэлэлцээр, Засгийн газраар бид нар оруулаад хэлэлцээд, Засгийн газар дэмжээд одоо Байнгын хороонд орж ирж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол бүх процесс Засгийн газраар дамжаад явж байгаа.

Мөн бас энэ хэлэлцээр батлагдаад ингээд хоёр талаасаа батлагдсаны дараа хамтарсан хороо байгуулаад, ажлын хэсэг байгуулаад ямар ямар тоног төхөөрөмж, хэзээ, яаж нийлүүлэх вэ гэдэг асуудал маань тодорхой болоод явах юм. Тэр үедээ дахиад бас Засгийн газраар оруулаад бид нар асуудлаа хэлэлцээд явна.

Тийм болохоор зөвхөн хүлээн авагч тал учраас Батлан хамгаалах яам гэдэг агуулгаар сая бас нэг талаасаа. Нөгөө талаасаа бол нь гадагшаа экспорт хийж байгаа болохоор бусад яамдууд оролцсон ийм юутай байж байгаа.

Энэ 9 сард, өнгөрсөн 9 сард Засгийн газрын хуралдаанаар орсон. Наранбаяр сайд бол гишүүнийхээ хувьд бас асуулт асууж байгаа байх, тэгж ойлгож байгаа. Яг энд бас ямар тоног төхөөрөмж, ямар бас техник хэрэгсэл орж ирэх вэ гэдэг дээр бол яг одоогоор тодорхой болсон зүйл байхгүй. Ерөнхий хэлэлцээрийг хийчхээд түүний дараад нь хамтарсан хороо, ажлын хэсэг байгуулагдаж байж тодорхой юуг авах вэ гэдэг тал дээр дараад нь бас ярилцах юм.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад?

Батсүмбэрэл гишүүнээр, Эрдэнэболд гишүүнээр тасалъя. Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Би хэлэлцээрийг дэмжиж байна. Ер нь Байнгын хорооны удирдлагатай ажлын албанд хандаад хэлэхэд ер нь энэ Монгол Улсад байгаа хэлэлцээрүүдийн жагсаалтууд, одоо мөрдөгдөж байгаа, хэрэгжиж байгаа, цаашид,

ойрын үед орж ирэхээр байгаа хэлэлцээрүүдийн жагсаалт гээд эд нарыг нэг гаргаж өгвөл болох уу?

Хоёрдугаарт, энэ гадаад яамтай бид нар танилцах асуудал байгаад байгаа. Энэ яагаад хойшлоод байгаа вэ? Ялангуяа энэ консул, элчингүүдийн асуудал яригдаад байгаа энэ үед бас энэ гадаад бодлогын чиглэлийн Байнгын хороо анхаарлаа тавих ёстой байх гэж бодож байна.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо саналыг хүлээж авлаа. Тэгээд ойрын хугацаанд бас очихоор төлөвлөж байгаа. Тодорхой хэлэлцээрүүдтэй холбоотой бас чиглэл өгсөн. Байнгын хорооны гишүүд ажиллах хугацаанд мэдээллүүдийг нэмж гаргаж өгөхийг бол бас Гадаад яаманд чиглэл болгосон байгаа.

Эрдэнэболд гишүүн үг хэлье.

**С.Эрдэнэболд:** Сүүлийн 19, 20 жилийн хугацаанд буюу хоёр 10 жилийн хугацаанд манай улсын батлан хамгаалах салбар бол энэ энхийг дэмжих ажиллагаа, НАТО-гийн мандаттай ажиллагаануудад оролцсоноор нэлээн их чадавхажсан. Ялангуяа хүний нөөц, хэл устай байдал тодорхой хэмжээнд бол энэ НҮБ-ын энэ үйл ажиллагаанд маш олон Монгол залуучууд оролцож, энэ чиглэлээр бол их сайн туршлагажиж байгаа. Тэр утгаараа бол бас Батлан хамгаалах яам бол энэ чиглэл дээр бол маш том том ахицууд байгаа. Тэгэхдээ мэдээж нөгөө олон нийтэд гараад л цэргийн хүчирхийлэл ч гэдэг юм уу, ямар нэгэн юм гээд л чих халууцуулаад байгаад байдаг болохоос биш бас ололттой, давуу сайн талуудыг нь бас бид нар үнэлдэг, дүгнэдэг байх ёстой. Нэг.

Хоёрдугаарт нь болохлоор энэ 30 хэдэн улстай ийм харилцаатай байгаа юм байна. Зүгээр яах вэ, тоног төхөөрөмжийн хувьд гэх юм бол түрүүний миний асуугаад байгаа нь нөгөө хуучирсан ч гэдэг юм уу, ингээд эдэлгээтэй болчихсон second hand гэж хэлдэг шүү дээ тийм зүйлийг л манай улс ус руу хөөрхий явуулаад байна уу? Эс үгүй бол яг цаг үеийн нөхцөл байдалд таарсан, технологийн хувьд бас яг энэ цаг үетэйгээ хөл нийлүүлсэн тийм зүйл аваад байна уу эд нар гэдэг чинь бас хоёр талтай. Тэгэхээр болж өгвөл бас энэ магадгүй нээлттэй ярих сэдэв биш байх. Тэгэхдээ энэ дээрээ бас ийм тодорхой мэдээлэл эд нар өгөхгүй бол яагаад гэхлээр энэ Байнгын хорооны хурал чинь хэвлэл мэдээллээр шууд явж байгаа, манай улсад байгаа бүх дип корпс, бүх улсууд л харж байгаа шүү дээ. Тэр утгаараа бол ерөнхийдөө оруулж ирээд ингээд битүү, хатуу байдлаар биш бас тодорхой хоёрдмол утгагүй тийм мэдээллийг өгөх тал дээр бас та бүхэн Батлан хамгаалах яамныхаа хэвлэлийн албаар ч юм уу дараа нь дамжуулаад бас гаргаарай.

Яагаад гэхлээр энэ бол энгийн тайван цаг биш байгаа шүү. Цаг хугацааны нөхцөл байдал, дээрээс нь энэ цагийн байдал чинь өөрөө ийм хурцадмал үед бас ийм эмзэг буюу сенситив мэдээлэл дээр бид нар бас ийм тодорхой, цэгцтэй, ойлгомжтой мэдээллийг Батлан хамгаалах яам ядаж өгөөд явах нь зөв байх гэдэг энэ саналыг хэлэх гэсэн юм.

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Батлан хамгаалах яам бас гишүүдийн хэлсэн саналыг бас анхаарч ажиллаарай гэж бас хэлэх байна.

Ингээд санал хураалт явуулж эхэлнэ.

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явахаар байгаа. Энэ бол ерөнхий хэлэлцээр, Засгийн газар эргээд ажлын хэсэг хоёр талаасаа байгуулаад, буцаагаад соёрхон батлахаар Улсын Их Хуралд бол бас орж ирнэ.

Ингээд санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 78.6 хувиар дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн тухай Байнгын хорооны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг бол Засгийн газарт хүргүүлнэ.

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Гишүүд, Ж.Энхбаяр гишүүн тэгсэн байсан. Саяын тэр Эрдэнэбүрэн, Ж.Энхбаяр гишүүд дэмжсэнээр санал хураалтад орох юм байна.

Тэгэхээр 13 гишүүн дэмжсэн байна. Ингээд хоёр улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Ажлын хэсэг, гишүүддээ баярлалаа.

14.17 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*